

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ажлаас чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг
түр орлон ажиллах этгээдийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ
НЬ:

1. “Улсын их дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Санжаагийн Сайнбат, хараат бус гишүүн Дашдондогийн Дашцэдэн нар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул дараагийн нөхөн сонгууль хүртэл тэдгээрийг түр орлон ажиллах гишүүнээр Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний шаардлагыг хангаж буй дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - 1.1. Монгол Улсын иргэн Мэндсоогийн Ганцэцэг (ХЖ67050665)
 - 1.2. Монгол Улсын иргэн Мөнхнасангийн Дамирансүрэн (ЧП44020211)
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан түр орлон ажиллах гишүүдэд Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6 дахь хэсэгт заасан үндэслэлийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүх эрхийг олгосугай.
3. Шинээр томилогдсон гишүүдэд холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, бусад дүрэм, журмыг мөрдлөг болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлагыг бүрэн ухамсарлаж ажиллахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



 Я.НАВААН